

БАТЛАВ.
МОНГОЛЫН ГАЗАРЗҮЙН
ОЛИМПИАДЫН ХОРООНЫ ДАРГА


В.БАТЦЭНГЭЛ
2026 оны 1 сарын 06

2025-2026 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ГАЗАРЗҮЙН УЛСЫН ОЛИМПИАДЫН
ХОЁРЫН ДАВАА ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Нэг. Үндэслэл, зорилго

- 1.1. Боловсролын ерөнхий газрын даргын 2023 оны 12 сарын 04-ний өдрийн А/420 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Улсын олимпиад зохион байгуулах журам”, Газарзүйн олимпиадын хорооны 2025 оны 9 сарын 30-ны 14 тоот шийдвэрт үндэслэн энэхүү удирдамжийг боловсруулав. Ерөнхий боловсролын сургуулийн багш, дунд, ахлах ангийн суралцагчдын дунд газарзүйн олимпиадын хоёрын даваа зохион байгуулахтай холбоотой харилцааг тус журмаар зохицуулна.
- 1.2. Ерөнхий боловсролын сургуулийн газарзүйн хичээлийн сургалтын чанар, үр өгөөжийг сайжруулах, сурагчдын бүтээлч сэтгэлгээ, чадварыг хөгжүүлж, газарзүйн ухааныг сонирхон судлах сурагчдын тоог нэмэгдүүлэх, багш нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэнэ. Тус олимпиадад ерөнхий боловсролын сургуулийн газарзүйн багш, суралцагчид хамрагдана.

Хоёр. Бүртгэл

- 2.1. Хоёрын даваанд оролцох сурагчдын тоог сургуулийн сурагчдын тоотой харгалзуулж тооцно. 1000 хүртэлх сурагчтай сургууль ангилал тус бүрт 1 сурагч, 1000-2000 сурагчтай сургууль ангилал тус бүрт 2 сурагч, 2000-3000 сурагчтай сургууль ангилал тус бүрт 3 сурагч, 3000-аас дээш сурагчтай сургууль ангилал тус бүрт 4 сурагч гэж тооцно.
- 2.2. Хоёрын даваанд шалгарсан сурагчдын мэдээлэл, имэйлийг geography.mn вэбсайтын “ХХХ олимпиад” цэснээс шалгаж, засах шаардлагатай бол засуулах хүсэлтээ 1 сарын 19-ны 20 цаг хүртэл geography.mongolia@gmail.com хаяг руу тодорхой бичиж илгээнэ. Бусад аргаар холбогдсон засвар, хоцорсон хүсэлт хүлээн авах боломжгүй. Оролцогчид мэйл рүүгээ олимпиадад ашиглах зөөврийн компьютерээс орох шаардлагатай тул имэйл рүүгээ орж чадаж байгаа эсэх, зөв бүртгүүлсэн эсэхийг нягтална. Имэйл рүү орж чадахгүй, буруу имэйл бүртгүүлсэн зэрэг гомдол засварын хугацаанаас хойш хүлээн авах боломжгүй.
- 2.3. Багшийн бүртгэлийг 2026 оны 1 сарын 19-ны 20 цаг хүртэл аймаг дүүрэг хариуцсан мэргэжилтэнгүүд нэгтгэж хороонд илгээнэ. Бүртгүүлсэн мэйлээр шалгалтын түлхүүр үг очих тул мэдээллээ сайтар шалгана.



Гурав. Ерөнхий зохион байгуулалт.

- 3.1. Хоёрын давааны сонгох даалгаврын хэсгийг багш нараас ирүүлсэн тестийг шүүн, шалгаруулж, цахим хэлбэрт оруулна. Сонгох даалгавруудыг geography.mongolia@gmail.com хаягаар 1 сарын 15 хүртэл хүлээн авна.
- 3.2. Хоёрын даваа 2026 оны 1 сарын 22-нд орон даяар бүх ЕБС зэрэг явагдана.
- 3.3. Хоёрын даваа exam.net вэбсайт дээр цахим хэлбэрээр болно.
- 3.4. 7, 8, 9 дүгээр ангийн сурагчид дунд ангийн төрөлд, 10, 11, 12 дугаар ангийн сурагчид ахлах ангийн төрөлд өрсөлдөнө.
- 3.5. Хоёрын даваа хоёр шаттай байна. Нэгдүгээр шатанд сонгох даалгавар ажиллах ба эхний 100 байранд шалгарсан багш сурагчид дараагийн шатанд оролцох эрхтэй болно. Эхний шат 10:00 цагт эхэлж 10:50 цагт дуусна.
- 3.6. Хоёрдугаар шат задгай даалгавар ажиллана. 13:00 цагт эхэлж, 14:40 минутад дуусна. Хоёрдугаар шатны засалтыг Улаанбаатар хотод нэгдсэн байдлаар хийнэ.
- 3.7. Сонгох даалгаврын оноо 25%, задгай даалгаврын оноо 75%-д тооцож, нийт оноог гаргах бөгөөд эхний 50 байрт шалгарсан багш, сурагчдын дүнг засалт дууссан даруй нэгтгэж, geography.mn вэбсайтын “XXX олимпиад” цэс дээр зарлана.
- 3.8. Засах болон эрэмбэлэх үйл ажиллагааг хорооны гишүүдийн хамт зохион байгуулна.

Дөрөв. Олимпиадын анги, орчин

- 4.1. Олимпиадыг газарзүйн кабинетаас өөр танхимд зохион байгуулна. Олимпиад зохион байгуулах кабинетэд ямар нэг газарзүйн хичээлтэй холбоотой газарзүйн зураг, мэдээлэл, ханын самбар байлгаж болохгүй.
- 4.2. 9:40 цагт мэргэжилтэнгээс өгсөн google meet рүү орсон байна. Google meet-ийн микрофон, камер нээж, камерт кабинетийн дотоод байдал бүтэн харагдахуйц байрлуулна. Камерт нийт оролцогчдын нүүр, гар харагдахуйц байх ёстой.
- 4.3. Google meet дээр хорооноос рекорд хийх ба олимпиадын үеэр микрофон, камер хаасан, meet-ээс гарсан, шалгалтын үеэр хоорондоо ярих, утас ашиглах, өөр компьютер ашиглах, хуулах оролдлого гарсан тохиолдолд тухайн сургуулийг олимпиадаас хасна.
- 4.4. Хоёрдугаар шатанд шалгарсан оролцогчдын шалгалтын орчин ижил байх ба google meet-ээр 12 цаг 40 минутаас эхлэн рекорд хийж эхэлнэ.
- 4.5. Олимпиадад зөвхөн зөөврийн компьютер ашиглан оролцно. Exam.net вэбсайт руу google chrome браузер ашиглаж орно. Google chrome браузер 91 болон түүнээс дараа гарсан хувилбар ашиглана.

Тав. Нэвтрэх үйл явц

- 5.1. Олимпиадын түлхүүр үг бүртгүүлсэн имэйл хаягаар очно.
- 5.2. Аймаг, дүүрэг, сургууль, сурагчийн нэрийг зөв форматаар оруулна. Имэйл буруу бичсэн тохиолдолд нэвтрэх боломжгүй. Хамрагдах харьяаллын мэдээллээ (аймаг, дүүргийн нэр, сургуулийн нэр) буруу оруулсан оролцогчийг эрэмбэд оруулах боломжгүй тул дараагийн зөв оруулсан оролцогчийг дэвшүүлэн тооцно. Энэ хэсэгт имэйлээс бусад мэдээллийг зөвхөн кирилээр бичнэ. Хавсаргасан зураг харна уу.

exam.net

Student

MNKpco UPDATE

Read more about our cheat-prevention systems

First name Өөрийн нэр

Last name Овог

Class Харьяалал Ж: Архангай, Эрдэнэбулган 3

Email И-мэйл

Teacher name Бэлтгэсэн багш

Phone number Оролцогчийн утасны дугаар

FETCH THE EXAM

Please enter some information about yourself. To read more about why we need your personal data, click [here](#).



Зургаа. Оролцох явц

- 6.1. Exam.net вэбсайт дээр тооны машин гарч ирэх тул бусад бүх төрлийн тооны машин хэрэглэхийг хориглоно.
- 6.2. Exam.net вэбсайтыг нээж ажиллахаас эхлээд “Submit” товчийг дарж илгээх хүртэл бүх алхамд google meet-д орсон байх ёстой. Иймд google meet-д орсон нөтбүүкний сүлжээ тасрахгүй байх, цэнэг дуусахгүй байх зэрэг нөхцлийг хангана. Google meet-ээс гарсан, камер хаасан, микрофон хаасан тохиолдолд ажиглагчийн протоколд үндэслэн, хорооны даргын шийдвэрээр олимпиадаас хасна.
- 6.3. Камерын дуранд анги бүтэн, оролцогчийн царай, бие, гар бүрэн орсон байх ёстой. Микрофон тасралтгүй нээлттэй байх ёстой. Олимпиадын явцад дуу чимээ гаргахыг хориглоно.
- 6.4. Олимпиадын хугацаанд тус сургуулиас оролцогч багш, сурагчаас өөр хүн ангид байж болохгүй.
- 6.5. Exam.net вэбсайт руу нэвтрэх, даалгавраа ажиллах, “Submit” товчийг дарж илгээх зэрэг үйлдлийг зөвхөн оролцогчид өөрөө гүйцэтгэх тул нөтбүүкний ажиллагаа, тохиргоог шалгаж, өөрөө хийж сурсан байх шаардлагатай. Нөтбүүкнээс хамаарсан асуудлаар олимпиадад оролцож чадаагүй тохиолдолд олимпиадын хороо хариуцахгүй.
- 6.6. Олимпиадын үеэр оролцогч ямар нэг сэжигтэй үйлдэл (бусадтай харилцах, хуулах г.м.) хийх оролдлого ажиглагдвал хүчингүйд тооцно.
- 6.7. Хугацаанаас өмнө дуусвал зөвшөөрөл авах шаардлагагүй бөгөөд “Submit” дарж илгээгээд “Өөрийн нэртэй шалгалт илгээсэн” гэсэн хар дэлгэц таньд харагдсаны дараа ангиас гарч болно. 11 цагаас хойш илгээсэн аливаа хариуг хүчингүйд тооцно.
- 6.8. Хоёрдугаар шат мөн ижил зарчмаар ажиллана.

Долоо. Туршилтын олимпиад

- 7.1. Туршилтын олимпиад 1 сарын 21-нд болно. Туршилтын олимпиад 1 сарын 22-ны олимпиадтай яг ижил нөхцлөөр бэлдэж орно. Туршилтын олимпиадын үед ашиглах зөөврийн компьютерийг ашиглан, бүх оролцогч орж ажиллана.
- 7.2. Туршилтын олимпиадад оролцоогүй, туршсанаас өөр зөөврийн компьютер ашигласан, имэйл рүүгээ нэвтэрч чадаагүй зэрэг техник хэрэгслээс үүдсэн ямарваа нэгэн гомдол, асуудлыг хүлээн авахгүй.

Найм. Байр эзлүүлэх тухай

- 8.1. Аймаг дүүрэг тус бүрийн эрэмбэ, гурвын даваанд ирэх оролцогчдын мэдээллийг засалт дуусангуут geography.mn “XXX олимпиад” цэс дээр зарлана.
- 8.2. Аймаг, дүүргийн боловсролын газраас медаль гардуулах үйл ажиллагааг хариуцан зохион байгуулна.

МОНГОЛЫН ГАЗАРЗҮЙН ОЛИМПИАДЫН ХОРОО

